БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/107/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Баянхонгор<br>2025 оны 02 дугаар сарын 25 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: narangerel batmunkh@audit.gov.mn<br>Баян ташаагийн эх аудит захирал т.Хоролсүрэн<br>Утас:99116028 Цахим хаяг: t.khorolsuren@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 15

**4.1 Ерөнхий зүйл** ........ 15

**4.2 Материаллаг байдал** ........ 16

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 16

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 16

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 17

**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 17

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 17

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 21


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/81

танай ____________-ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ц.ЦЭРЭНХҮҮ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй Тайланд онд 1,032,535.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлийн санхүүжилт 969,695.1 мянган төгрөг авч, 903,546.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд

6426050255

нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Жинст сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 1 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 88 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **162,019,871.66** | **167,308,288.52** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **10,203,591.94** | **73,779,707.68** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **10,203,591.94** | **73,779,707.68** |
| **31210** | **Төгрөг** | **10,203,591.94** | **73,779,707.68** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,203,591.94 | 73,779,707.68 |
| **32** | **АВЛАГА** | **72,719,892.86** | **27,862,374.35** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 72,719,892.86 | 27,862,374.35 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **79,096,386.86** | **65,666,206.49** |
| **35100** | **Түүхий эд материал** | **64,914,056.86** | **51,594,376.49** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 55,622,368.26 | 42,045,211.59 |
| 35130 | Эм боох материал | 9,291,688.60 | 9,549,164.90 |
| **35400** | **Хангамжийн материал** | **14,182,330.00** | **14,071,830.00** |
| 35420 | Аж ахуйн материал | 4,876,280.00 | 1,947,280.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,306,050.00 | 12,124,550.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,656,261,059.42** | **1,550,737,698.91** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,656,261,059.42** | **1,550,737,698.91** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,653,333,059.42** | **1,547,809,698.91** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,350,112,398.64 | 1,350,112,398.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -90,608,188.39 | -118,134,253.75 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 232,664,366.47 | 225,904,366.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -42,050,343.70 | -73,128,404.82 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 330,481,571.06 | 334,017,497.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -143,398,437.10 | -180,846,737.57 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,366,445.02 | 51,083,593.64 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -39,074,752.58 | -41,768,760.76 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,337,271.86 | 1,825,751.56 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,797,271.86 | -1,555,751.56 |
| 39217 | Ном | 300,000.00 | 300,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **2,928,000.00** | **2,928,000.00** |
| 39301 | Програм хангамж | 670,000.00 | 670,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -670,000.00 | -670,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,928,000.00 | 2,928,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,818,280,931.08** | **1,718,045,987.43** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,818,280,931.08** | **1,718,045,987.43** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,818,280,931.08 | 1,718,045,987.43 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 295,911,043.12 | 295,911,043.12 |
| 51101 | Өмч - төрийн | 295,911,043.12 | 295,911,043.12 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,148,132,500.94** | **1,047,897,557.29** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,148,132,500.94 | 1,148,132,500.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -100,234,943.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 374,237,387.02 | 374,237,387.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,818,280,931.08** | **1,718,045,987.43** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,185,769,613.41** | **929,207,896.16** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **366,972,972.07** | **4,370,316.06** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 366,972,972.07 | 4,370,316.06 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,400,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,400,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **818,796,641.34** | **924,837,580.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 1,368,763.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,368,763.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 51,792,200.00 | 67,299,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,792,200.00 | 67,299,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 767,004,441.34 | 856,168,917.10 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 767,004,441.34 | 856,168,917.10 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **901,706,414.36** | **1,029,442,839.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **901,706,414.36** | **1,029,442,839.81** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 901,355,039.36 | 1,026,370,798.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 578,296,519.47 | 645,994,709.28 |
| 210101 | Үндсэн цалин | 351,424,181.29 | 342,719,954.49 |
| 210102 | Нэмэгдэл | 159,013,331.18 | 221,036,656.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,633,000.00 | 21,724,998.00 |
| 210104 | Урамшуулал | 55,226,007.00 | 60,513,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 71,091,998.00 | 78,943,921.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,346,526.00 | 52,764,267.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,696,247.00 | 6,315,138.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,048,126.00 | 3,157,968.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,291,000.00 | 3,157,968.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,710,100.00 | 13,548,580.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,360,825.00 | 59,729,859.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,449,201.00 | 7,020,388.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,191,624.00 | 51,549,471.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 720,000.00 | 1,160,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,815,750.00 | 56,098,976.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,503,250.00 | 2,863,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,875,600.00 | 26,833,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,084,800.00 | 264,880.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,372,100.00 | 13,138,703.93 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 11,018,142.85 |
| **2105** | **Нормативт зардал** | 81,596,449.20 | 52,288,940.24 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 74,010,799.20 | 43,190,640.24 |
| 210502 | Хоол, хүнс | 7,585,650.00 | 9,098,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,699,100.00 | 6,806,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,699,100.00 | 6,806,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,468,000.00 | 3,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,468,000.00 | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | 3,822,713.00 | 7,122,032.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,364,400.00 | 3,939,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 175,750.00 | 211,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 169,253.00 | 476,392.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 58,310.00 | 39,890.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 81,203,684.69 | 115,885,860.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,942,700.00 | 1,712,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,260,984.69 | 114,173,460.51 |



005

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 351,375.00 | 3,072,041.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 351,375.00 | 2,572,041.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 351,375.00 | 2,572,041.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **284,063,199.05** | **-100,234,943.65** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН** | **284,063,199.05** | **-100,234,943.65** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **772,149,035.48** | **969,695,098.61** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,400,000.00** | **1,368,763.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 15,400,000.00 | 1,368,763.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,400,000.00 | 1,368,763.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,400,000.00 | 1,368,763.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **756,749,035.48** | **968,326,335.61** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 51,792,200.00 | 67,299,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,792,200.00 | 67,299,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 704,956,835.48 | 901,026,435.61 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 704,956,835.48 | 901,026,435.61 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **794,212,421.47** | **901,368,982.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **794,212,421.47** | **901,368,982.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **793,861,046.47** | **898,296,941.87** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 578,296,518.47 | 645,994,709.28 |
| 210101 | Үндсэн цалин | 351,424,181.29 | 342,719,954.49 |
| 210102 | Нэмэгдэл | 159,013,330.18 | 221,036,656.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,633,000.00 | 21,724,998.00 |
| 210104 | Урамшуулал | 55,226,007.00 | 60,513,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 71,091,999.00 | 78,943,921.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,346,526.00 | 52,764,267.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,696,247.00 | 6,315,138.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,048,126.00 | 3,157,968.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,291,000.00 | 3,157,968.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,710,100.00 | 13,548,580.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,360,825.00 | 59,729,859.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,449,201.00 | 7,020,388.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,191,624.00 | 51,549,471.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 720,000.00 | 1,160,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,669,250.00 | 38,473,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,503,250.00 | 2,863,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,875,600.00 | 26,833,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,046,800.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,263,600.00 | 6,555,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,870,241.00 | 55,241,570.59 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 43,524,591.00 | 43,795,270.59 |
| 210502 | Хоол, хүнс | 7,585,650.00 | 9,098,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 760,000.00 | 2,348,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,388,800.00 | 7,334,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 850,000.00 | 00.00 |



005

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 8,538,800.00 | 7,334,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,468,000.00 | 3,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,468,000.00 | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,822,713.00 | 7,366,832.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,364,400.00 | 3,999,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 175,750.00 | 211,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 169,253.00 | 476,392.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,384,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 58,310.00 | 39,890.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,892,700.00 | 1,712,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,892,700.00 | 1,712,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **351,375.00** | **3,072,041.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 351,375.00 | 2,572,041.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 351,375.00 | 2,572,041.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-22,063,385.99** | **68,326,115.74** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **00.00** | **4,750,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **4,750,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 4,750,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 4,750,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **00.00** | **-4,750,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | -22,063,385.99 | 63,576,115.74 |
| **101** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 32,266,977.93 | 10,203,591.94 |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 10,203,591.94 | 73,779,707.68 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 295,911,043.12 | 375,307,078.81 | -70,436,433.54 | 00.00 | 600,781,688.39 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **295,911,043.12** | **375,307,078.81** | **-70,436,433.54** | **00.00** | 600,781,688.39 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 6,284,361.51 | 00.00 | 6,284,361.51 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **295,911,043.12** | **374,237,387.02** | **1,148,132,500.94** | **00.00** | 1,818,280,931.08 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **295,911,043.12** | **374,237,387.02** | **1,148,132,500.94** | **00.00** | 1,818,280,931.08 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **295,911,043.12** | **374,237,387.02** | **1,148,132,500.94** | **00.00** | **1,818,280,931.08** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -100,234,943.65 | 00.00 | -100,234,943.65 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **295,911,043.12** | **374,237,387.02** | **1,047,897,557.29** | **00.00** | **1,718,045,987.43** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,042,739,500.00 | 969,695,098.61 | 73,044,401.39 | 93.0 |
| 310002 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 67,299,900.00 | 67,299,900.00 | - | 100.0 |
| | Орон нутгийн төсвөөс | 67,299,900.00 | 67,299,900.00 | - | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 963,867,300.00 | 901,026,435.61 | 62,840,864.39 | 93.5 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 963,867,300.00 | 901,026,435.61 | 62,840,864.39 | 93.5 |
| **35** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 11,572,300.00 | 1,368,763.00 | 10,203,537.00 | 11.8 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,368,700.00 | 1,368,763.00 | (63.00) | 100.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 10,203,600.00 | - | 10,203,600.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,042,739,500.00 | 903,546,941.87 | 139,192,558.13 | 86.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,042,739,500.00 | 903,546,941.87 | 139,192,558.13 | 86.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,041,739,500.00 | 903,046,941.87 | 138,692,558.13 | 86.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 696,917,400.00 | 645,994,709.28 | 50,922,690.72 | 92.7 |
| 210101 | Үндсэн цалин | 368,192,600.00 | 342,719,954.49 | 25,472,645.51 | 93.1 |
| 210102 | Нэмэгдэл | 236,132,400.00 | 221,036,656.79 | 15,095,743.21 | 93.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,716,400.00 | 21,724,998.00 | 7,991,402.00 | 73.1 |
| 210104 | Урамшуулал | 62,876,000.00 | 60,513,100.00 | 2,362,900.00 | 96.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 86,891,400.00 | 78,943,921.00 | 7,947,479.00 | 90.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,514,600.00 | 52,764,267.00 | 5,750,333.00 | 90.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,094,300.00 | 6,315,138.00 | 779,162.00 | 89.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,547,100.00 | 3,157,968.00 | 389,132.00 | 89.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,547,100.00 | 3,157,968.00 | 389,132.00 | 89.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,188,300.00 | 13,548,580.00 | 639,720.00 | 95.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 62,299,900.00 | 59,729,859.00 | 2,569,041.00 | 95.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,899,900.00 | 7,020,388.00 | 3,879,512.00 | 64.4 |
| 210302 | Түлш, халаалт | 49,800,000.00 | 51,549,471.00 | -1,749,471.00 | 103.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,600,000.00 | 1,160,000.00 | 440,000.00 | 72.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 54,593,400.00 | 38,473,150.00 | 16,120,250.00 | 70.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,016,300.00 | 2,863,300.00 | 1,153,000.00 | 71.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,372,000.00 | 26,833,950.00 | 12,538,050.00 | 68.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,237,100.00 | 1,980,000.00 | 257,100.00 | 88.5 |
| 210404 | Ном, хэвлэл | 768,000.00 | 240,000.00 | 528,000.00 | 31.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,200,000.00 | 6,555,900.00 | 1,644,100.00 | 80.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 89,014,600.00 | 55,241,570.59 | 33,773,029.41 | 62.1 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,739,900.00 | 43,795,270.59 | 27,944,629.41 | 61.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 13,024,700.00 | 9,098,300.00 | 3,926,400.00 | 69.9 |
| 210502 | Хоол, хүнс | 4,250,000.00 | 2,348,000.00 | 1,902,000.00 | 55.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 25,500,000.00 | 12,084,500.00 | 13,415,500.00 | 47.4 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,000,000.00 | 1,800,000.00 | 9,200,000.00 | 16.4 |
| 210604 | Урсгал засвар | 14,500,000.00 | 10,284,500.00 | 4,215,500.00 | 70.9 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,200,000.00 | 3,500,000.00 | 1,700,000.00 | 67.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,200,000.00 | 3,500,000.00 | 1,700,000.00 | 67.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 10,577,900.00 | 7,366,832.00 | 3,211,068.00 | 69.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,128,000.00 | 3,999,400.00 | 2,128,600.00 | 65.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 211,350.00 | 38,650.00 | 84.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 700,000.00 | 476,392.00 | 223,608.00 | 68.1 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 105,000.00 | 55,000.00 | 50,000.00 | 52.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 2,094,900.00 | 1,384,800.00 | 710,100.00 | 66.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 100,000.00 | 39,890.00 | 60,110.00 | 39.9 |
| 210807 | Газрын төлбөр | 10,744,900.00 | 1,712,400.00 | 9,032,500.00 | 15.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,744,900.00 | 1,712,400.00 | 9,032,500.00 | 15.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 50.0 |
| | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 50.0 |
| | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,000,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 50.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 10,203,591.94 | (10,203,591.94) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 73,779,707.68 | (73,779,707.68) | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24 | 19 | 5 | 79.2 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17 | 13 | 4 | 76.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 5 | 1 | 83.3 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | 24 | 19 | 5 | 79.2 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 18 | 14 | 4 | 77.8 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6 | 5 | 1 | 83.3 |



005

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жинст сумын эрүүл мэндийн төв нь сумын иргэдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж чанар хүртээмжийг сайжруулан, иргэдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж, хүн амд эрүүл аж төрөх зан үйлчилгээг төлөвшүүлэх, орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгын хүрээнд тайлант онд дараах 8 зорилт 57 арга хэмжээг хэрэгжүүлэн 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Ц.Цэрэнхүү, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Төмөрбат нар зурж, нярваар А. Нямдорж нар ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Эрүүл мэндийн яамнаас хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жинст сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,235.0 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,203.6 | 73,779.7 | 63,576.1 |
| Авлага | 72,719.9 | 27,862.3 | -44,857.6 |
| Бараа материал | 79,096.4 | 65,666.2 | -13,430.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,973,860.0 | 1,966,841.6 | -7,018.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | -317,599.0 | -416,103.9 | -98,504.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,818,280.9** | **1,718,045.9** | **-100,235.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,818,280.9 | 1,718,045.9 | -100,235.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,818,280.9** | **1,718,045.9** | **-100,235.0** |

*Эх сурвалж: Жинст суиын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан*

Тайлант онд оны эхэнд 10,203.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 73,779.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 63,576.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэл 44,857.5 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДаатгалын сангаас авах авлага оны эхний үлдэгдэл төлөгдсөнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 100,286.4 мянган төгрөгийн бараа материал 470.2 мянган төгрөгийн бараа үнэ төлбөргүй орлого авч, үйл ажиллагаандаа 103,168.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/24 тоот тушаалаар 3,398.9 мянга, 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/41 тоот тушаалаар 7,619.2 мянга нийт

11,018.1 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжгүй болсон бараа материал акталж бараа материалын үлдэгдэл 13,430.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд Эрүүл мэндийн яам, аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,900.1 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,750.0 мянга нийт 8,650.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 3 дугаар сарын 11-ний 6/04 тоот тогтоолоор 9,955.6 мянга, 2025 оны 12 дугаар сарын 01-ны 9/60 тоот тогтоолоор 5,712.9 мянга нийт 15.668.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж 473.0 мянган төгрөгөөр сунгасан байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 100,235.0 мянган төгрөгөөр буурч 1,718,045.9 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 100,235.0 мянган төгрөгөөр буурч 1,718,045.9 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 988,360.6 мянга, орон нутгийн төсвөөс 67,986.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 1,056,347.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 1 удаа тодотгол хийж эрүүл мэндийн даатгалын сангаас 963,867.3 мянга, орон нутгийн төсвөөс 67,299.9 мянга, үйл ажиллагааны орлогоос 1,368.7 мянга төгрөгөөр нийт зардлыг 1,032,535.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 963,867.3 мянган төгрөг төлөвлөж 901,026.4 мянга, орон нутгийн төсвөөс 67,299.8 мянган төгрөг төлөвлөж 67,299.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 1,368.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Урд оны үлдэгдэл 10,203.6 мянган төгрөг байсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 903,546.9 мянган төгрөг буюу 86,7 хувьтай 2,572.0 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Улсын төсвийн харилцах дансны үлдэгдэл 73,779.7 мянган төгрөг байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*
(мянган төгрөгөөр)

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71602 | Эрүүл мэндийн туслам үйлчилгээ | 1,042,739.5 | 903,546.9 | 139,192.6 | 86.7 |
| 80302 | Нэг иргэнд ноогдох нормативаар | 706,563.2 | 646,172.3 | 60,390.9 | 91.5 |
| 80111 | Нийтлэг үйлчилгээ | 67,299.9 | 64,727.9 | 2,572.0 | 96.2 |
| 81603 | Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 194,787.8 | 136,213.0 | 58,574.8 | 69.9 |
| 83603 | Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан | 74,088.6 | 56,433.7 | 17,654.9 | 76.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нийт батлагдсан төсөв 1,042,739.5 мянган төгрөгийг 86.7 хувь зарцуулж, орон нутгийн төсвөөс 2,572.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

1. Байгууллага бүтэц, орон тоог 24 орон тоотой баталсан бөгөөд бүтэц орон тооны цомхотгол хийгээгүй, 696,917.4 мянга төгрөгийн төсөв баталсан ба гүйцэтгэлээр 19 орон тоотой 645,994.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2. Хоолны зардлыг 1 өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож 29,716.4 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 21,725.0 мянган төгрөгийг зарцуулсан.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 46,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 46,000.0 мянган төгрөгийн шатахуун нийлүүлэх, нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар 2025 оны 2 дугаар сарын 01-ны худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-;-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян ташаагийн эх аудитын ахлах аудитор Б.Хандсүрэн, аудитор Д.Балжирдорж нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Хоролсүрэн дараагийн шатны хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсөв 1,041,400.0 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,041,400.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,414.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар зөрчил илрээгүй

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 166 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 935,467.2 мянган төгрөгийн 37 гүйлгээ, зарлагын 45,665.5 мянган төгрөгийн 6 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 101,899.1 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэх зөвлөмж өгсөн. Баянхонгор аймгийн өмчийн газар 2026 оны 1 дүгээр улиралд багтаан асуудлыг шийдвэрлэх хариу өгсөн байна. Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 3,042.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 2,942.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

*Хүснэгт 4 Албан шаардлагын* хэрэгжилт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 100.0 | 1 | 100.0 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 2,942.0 | 1 | 2,942.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | 3,042.0 | **2** | 3,042.0 | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 101,899.1 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн шийдвэрийг авч үзэх.

2.Дараагийн аудитаар Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллаж байгааг авч үзнэ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------oOo-----------